



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 665

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийт 3,662,241,911.00 (гурван тэрбум зургаан зуун жаран хоёр сая хоёр зуун дөчин нэгэн мянга есөн зуун арван нэгэн) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Цаг уур, орчны шинжилгээний газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Урьдчилан мэдээлэх хэлтсийн дарга Л.Оюунжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн
655 дугаар тогтоолын хавсралт

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАНСАНД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ(төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл(төгрөг)	Үлдэх өртөг(төгрөг)
1	Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антений цамхгийн байр	12/16/2022	1,296.71	м2	3,662,241,911	-	3,662,241,911
Нийт							
					3,662,241,911 (гурван тэрбум зургаан зуун жаран хоёр сая хоёр зуун дөчин нэгэн мянга есөн зуун арван нэгэн)	(тэг)	3,662,241,911 (гурван тэрбум зургаан зуун жаран хоёр сая хоёр зуун дөчин нэгэн мянга есөн зуун арван нэгэн)